



ЦЭЦЭЭ ГҮН РОТАРАКТ КЛУБ
"ХҮН БҮР СУРАХ ЭРХТЭЙ" ТӨСӨЛ
MENTORSHIP 6 — ХӨТӨЛБӨР

ТӨСЛИЙН НЭР: ХҮН БҮР СУРАХ ЭРХТЭЙ
ЧИГЛЭЛ: БОЛОВСРОЛ
ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: ЦЭЦЭЭ ГҮН РОТАРАКТ КЛУБ

УЛААНБААТАР
2026

1

МЕНТОРШИП ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Менторшип гэж юу вэ?

Менторшип гэдэг нь арвин туршлага болон мэдлэг, чадвартай мэргэжилтэн нь туршлага багатай залууст ажил, карьерынх нь тал дээр зөвлөгөө өгч чиглүүлдэг харилцаа юм.

Ментор

Ментор нь тухайн салбартаа туршлага хуримтлуулсан, мэдлэг боловсрол өндөртэй хүн байх бөгөөд ментийдээ ажил мэргэжил, хувь хүний хөгжил дээр зөвлөгөө өгч, туршлагаасаа хуваалцахын зэрэгцээ дэмжлэг үзүүлэх юм.

Ментий

Ментий гэдэг нь ментороос зөвлөгөө авах, тэдний туршлагаас суралцах, үүлзалт, сургалт хийх замаар өөрийн хүсэл сонирхол, чадварыг нээн илрүүлэх, хувь хүний хөгжил, карьераа хөгжүүлэхээр зорьж буй хүнийг хэлнэ.

2

ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

"Цэцээ Гүн" Ротаракт клуб нь Олон Улсын Ротари хөдөлгөөний Монгол Улс дахь салбар бөгөөд 2013 оноос хойш шашны бүс, ашгийн бүс, төрийн бүс байгууллага хэлбэрээр энх тайван, хямрал зохицуулалт; өвчний эмчилгээ, оношилгоо; боловсрол, бичиг үсэг тайлагдалт; эх, хүүхдийн эрүүл мэнд; эдийн засаг, бүс нутгийн хөгжлийг дэмжих; ус, эрүүл ахуй болон хүрээлэн буй орчныг хамгаалах гэсэн үндсэн долоон чиглэлийн дагуу манлайлагч залуусыг нэгтгэн үйл ажиллагаагаа идэвхтэй явуулсаар ирсэн.

"Цэцээ Гүн" Ротаракт клубийн нэрийн гол төсөл болох "Хүн бүр сурах эрхтэй" төслөө бид 2015 оноос эхлэн хэрэгжүүлж, 50 оюутанд 68 сая төгрөгийн сургалтын тэтгэлгийг олгосон байна.

2020 оноос цахимаар Менторшип хөтөлбөрөө 11 ментор, 11 ментийтэй эхлүүлж, Менторшип 2-г 15 ментор 15 ментийтэй амжилттай зохион байгуулсан. Менторшип 3-г Монгол болон Америкийн 7 ментор мөн үр чадварын 3 ментортойгоор зохион байгуулсан.

Энэ жилийн 7 чиглэл

- ◆ Хиймэл оюун
- ◆ Боловсрол (Боловсрол судлал, Багшийн хөгжил)
- ◆ Сэргээгдэх эрчим хүч
- ◆ Уул уурхай

- ◆ Хууль, эрх зүй
- ◆ Сэтгэл судлал
- ◆ Медиа, маркетинг

Ур чадварын менторын чиглэл

Ментий нарийн хувийн ур чадварыг сайжруулах зорилгоор явуудах хувийн хөгжлийн сургалтууд

- ◆ Тэтгэлэг, эсээ, англи хэл сурах тал дээр зөвлөх ментор
- ◆ Эрүүл мэндийн ментор
- ◆ Сэтгэл зүйч ментор
- ◆ Мини хакатон багтсан

3

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

!

3 болон түүнээс дээш курсийн оюутан болон дээд сургуулиа төгсөөд 2 хүртлэх жил болсон залуучуудад хувь хүний хөгжил, өөрсдийн нөөц бололцоогоо тодорхойлох, гадаадад суралцах, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж, ментор мэргэжилтнүүдээр дамжуулан тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө өгч, амжилттай залуу мэргэжилтэн болоход дэмжлэг үзүүлэхэд оршино.

4

ХӨТӨЛБӨРИЙН ОНЦЛОГ

Ирээдүйд Монгол улсын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах 7 салбарт төвлөрч явагдана. Бүх ментий нар мэргэжлийн чиглэлийн ментороос гадна үр чадварын 3 ментортой байна. Нэг долоо хоногт 1-2 удаа ментортойгоо холбогдон уулзана.

- ◆ Мэргэжлийн салбарын гадаад болон Монгол ментортой.
- ◆ Бүх ментий нар мэргэжлийн ментороос гадна үр чадварын 3 ментортой (Биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, Тэтгэлэг хөтөлбөрт хамрагдах, англи хэл сурах гэх мэт).
- ◆ Ментийд долоо хоног бүр юу сурснаа тайлагнах үүрэгтэй, суралцах үр чадварын сэдэв, чиглэлтэйгээр үр дүнтэй оролцож нэн шаардлагатай чадваруудыг эзэмшинэ.
- ◆ Ментий нараас сонгон шалгаруулж тэтгэлэг олгоно.

5

ХӨТӨЛБӨРТ ЮУ БАГТСАН БЭ?**Сургалтын агуулга**

- ◆ Сургалт 1: Тэтгэлэгт хамрагдах, Англи хэл сурах
- ◆ Сургалт 2: Биеийн эрүүл мэнд сургалт
- ◆ Сургалт 3: Сэтгэлзүйн эрүүл мэндийн сургалт
- ◆ Сургалт 4: Мини хакатон
- ◆ Бусад менторуудтай танилцах уулзалт: Хөтөлбөрийн хаалт, нээлт мөн дундуур.

Оролцогчдод олгох боломж

- ◆ Мэдлэг хуваалцах уулзалтууд, сургалт
- ◆ Менторуудаас тусгаачлан зөвлөгөө авах
- ◆ Бусад салбаруудын мэргэжилтнүүдтэй танилцах уулзалт

6

МЕНТОРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

- ◆ Сайн дурын ажил тогтмол хийдэг
- ◆ Салбартаа танигдсан нэр хүндтэй
- ◆ Их дээд сургуулийг бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй төгссөн байх
- ◆ Таваас доошгүй жил ажиллаж, туршлага хуримлуулсан байх
- ◆ Англи хэлний ахисан шатны мэдлэгтэй байх
- ◆ Энэхүү хөтөлбөрт хоёр долоо хоногт хоёроос доошгүй цагийг зарцуулах боломжтой байх
- ◆ Ментийдээ зөвлөгөө өгч, зааж сургах чадвартай, бусадтай нээлттэй, хүндэтгэлтэй харьцдаг байх

7

ХӨТӨЛБӨРИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА

Үе шат	Үйл ажиллагаа	Хэл	Огноо
Нээлт	Нээлтийн үйл ажиллагаа	Англи / Монгол	2026.3.28
Ментор нарын чиглүүлэх сургалт	Хөтөлбөрийн хүрээнд ажиллах чиглүүлэлт	Синхрон	2026.03.22
Ментий нарын чиглүүлэх сургалт	Эхний уулзалт, төлөвлөгөө, тайлан авах	Монгол	2026.03.29
Хөгжүүлэх сургалт #1	Тэтгэлэгт хамрагдах, Англи хэл + Нетворкинг	Монгол	2026.04.04
Хөгжүүлэх сургалт #2	Биеийн эрүүл мэнд сургалт	Монгол	2026.04.11
Хөгжүүлэх сургалт #3	Сэтгэлзүйн эрүүл мэндийн сургалт	Монгол	2026.04.18
Мини Хакатон	Хамтарсан үйл ажиллагаа	Монгол	2026.04.25
Хаалт	Хаалтын арга хэмжээ · Тэтгэлэг гардуулах	Англи / Монгол	2026.05.02

8

ХЭН ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ ВЭ?

- ◆ 3-с дээш курсийн оюутнууд, төгсөөд 2 жил болсон залуу мэргэжилтнүүд
- ◆ Ижил төстэй хөтөлбөрт өмнө нь хамрагдаж байгаагүй байх
- ◆ Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх
- ◆ Энэхүү хөтөлбөрт долоо хоногт хоёроос доошгүй цагийг зарцуулах боломжтой байх
- ◆ Бусадтай нээлттэй, хүндэтгэлтэй харьцдаг, зөвлөгөө хүлээж авч, хэрэгжүүлэх чадвартай байх

! Хөтөлбөрийн турш долоо хоног бүр ментортойгоо холбогдож зөвлөгөө авсан байх ба тус хөтөлбөрөөр хийсэн ажил, суралцсан зүйлсийн тэмдэглэл долоо хоног бүр оруулж мэдээлэх даалгавартай байна.

Даалгаварыг 4-с дээш удаа хангалттай гүйцэтгэсэн, хөтөлбөрийг бүрэн дуусгасан ментийд батламж олгоно.

9

ХЭРХЭН БҮРТГҮҮЛЭХ ВЭ?

Цахим өргөдлийн маягтыг бөглөх замаар бүртгүүлнэ үү. QR кодыг уншуулан Ментийд бүртгүүлэх маягтыг бөглөнө үү.



✦ ХОЛБОО БАРИХ ✦

facebook.com/ractsetseegung

☎ 8815-2992 | 9120-4926

✉ tsetseegung@gmail.com